

**БҮГД НАЙРАМДАХ АВСТРИ УЛСЫН  
ПАРЛАМЕНТИЙН СОНГУУЛЬ  
/2017.10.15/**

Бүгд Найрамдах Австри Улс нь Төв Европд байрладаг, далайд гарцгүй орон бөгөөд нийт 8.7 сая хүн амтай, 83,879 км<sup>2</sup> нутагтай. Тус улс хойд талаасаа Чех, Герман, зүүн талаасаа Унгар, Словак, өмнө талдаа Словени, Итали, баруун талдаа Швейцарь болон Лихтенштейн гэх 8 улстай хиллэдэг байна. Албан ёсны хэл Герман. Тус улс 9-н автономит аймаг Бургенланд, Каринтия, Доод Австри, Дээд Австри, Салцбург, Стириа, Тирол, Ворарлберг болон Вена хотоос бүрдэнэ. Эдгээр аймгууд онцгой гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг ч шүүхийн систем нь тусдаа биш бөгөөд орон нутгийн парламент хууль тогтоох байгууллагатай. Тус бүр өөрсдийн сонгуулийн хууль, сонгуулийн удирдлагын байгууллагатай. Харин улс даяар зохион байгуулах сонгуульд Холбооны сонгуулийн хуулийг мөрддөг.

Улс даяар зохион байгуулдаг сонгуульд: Үндэсний Зөвлөлийн сонгууль (Үндэсний Парламентийн сонгууль), Европын сонгууль, Ерөнхийлөгчийн сонгууль;

Орон нутгийн сонгуульд: Орон нутгийн парламентийн сонгууль, хотын захиргааны сонгууль, хотын даргын сонгууль орно. .

Холбооны түвшинд хоёр гол сонгууль байдаг нь Засгийн газрын тэргүүн, Холбооны Ерөнхийлөгчийн сонгууль юм. Холбооны Ерөнхийлөгчийг 6 жил тутам сонгох ба сонгуулиар 50-аас дээш хувийн санал авсанаар сонгогдож, хэрэв аваагүй тохиолдолд дахин санал хураалт явуулдаг. Парламентын хоёр танхимтай, дээд танхим Бундесрат (Холбооны зөвлөл) 61 гишүүнтэй, доод танхим Националрат (Үндэсний зөвлөл) 183 гишүүнтэй. Үндэсний Зөвлөлийн гишүүдийг хувь тэнцүүлэх төлөөллийн аргаар 5-н жилийн хугацаатай сонгодог.

БНАУ нь олон намын системтэй. 1945-аас 1986 оны хооронд гол хоёр намтай байсан ба гурав дахь намууд мөн Үндэсний Зөвлөлд сонгогддог байв. 1986 оноос хойш ерөнхийдөө 5 жилийн турш 4 намтай байжээ. Үндэсний Зөвлөлд сонгогдохын тулд аль нэг бүсийн тойргоос хамгийн багадаа 4 хувийн бүх нийтийн санал, парламентад суудал авсан байх хэрэгтэй байдаг.



Сонгогчдын хувьд, 16 ба түүнээс дээш насны Австри Улсын иргэн сонгууль өгөх эрхтэй. Мөн тус улсад байнга оршин суух эрхтэй Европын Холбооны гишүүн орнуудын иргэд Европын Холбооны болон орон нутгийн сонгуульд оролцдог байна. Нэг жилээс дээш хугацаагаар хорих ял авсан иргэнд сонгуульд саналаа өгөх эрхгүй.

Энэ удаагийн Парламентийн сонгуульд 6,401,304 иргэд саналаа өгөхөөр бүртгэгдсэнээс 3,307,795 эмэгтэй, 3,093,509 нь эрэгтэй сонгогч байна. Үүнээс 60,749 нь саналаа өгөхөөр бүртгүүлсэн гадаад улсад байгаа Австрийн иргэд юм. Шуудангаар саналаа өгөхөөр нийт 889,193 саналын хуудас авах өргөдөл ирсэн нь 2013 онд 668,810 саналын хуудас авч байснаас их байгаа юм.

Австри Улсад 2017 оны 10-р сарын 15-ны Ням гаригт Хууль тогтоох байгууллагын сонгууль зохион байгуулагдлаа.

Сонгуульд нэр дэвшсэн намуудаас Австрийн Ардын нам нь Үндэсний зөвлөлийн 163 суудлаас 61 суудлыг авч хамгийн олон суудалтай нам болж байна. Харин Эрх чөлөө нам 52 суудал авсан Социал демократ намтай бараг адил тооны буюу 51 суудал авчээ. 2013 онд болсон Парламентийн өмнөх сонгуулиар Социал Демократ нам хамгийн их суудлыг авч байсан бол энэ удаа тус нам Австри-Унгарын эзэнт гүрний асуудлаас болж хоёр том намын аль нь ч болж чадсангүй.

Австрийн Засгийн газрын тэргүүн буюу Канцеллераар хамгийн их суудал авсан намын удирдагч ажилладаг. Үндэсний зөвлөлийн гишүүдийг мужууд дахь (суудлын тоо нь 7-36 хооронд байна) олон мандат бүхий 9-н тойргоос, сонгуулийн дэд 39-н тойргоос нээлттэй жагсаалтаар хувь тэнцүүлсэн төлөөллийн аргаар сонгодог. Суудлын хуваарилалтдаа дэд тойргийн түвшинд “Hare method” аргаар, холбооны түвшинд Д’Ондт-ын аргыг ашигладаг байна.



Австрийн Ардын нам  
 Австрийн Социал Демократ нам  
 Австрийн Эрх чөлөө нам  
 Шинэ Австри нам  
 Петр Пилзийн жагсаалт

2017 оны Парламентийн сонгуулийн үр дүнг хүснэгтээр үзүүлбэл:

Намын нэр	Авсан санал	%	Суудлын тоо		+/-
Австрийн Ардын нам	1,538,409	31.7	62		+15
Социал Демократ нам	1,292,902	26.7	52		0
Австрийн Эрх чөлөө нам	1,284,262	26.5	51		+11
НЭОС-Шинэ Австри нам	249,903	5.3	10		+1
Петр Пилз-н жагсаалт	205,382	4.2	8		Шинэ
Ногоон нам–Ногоон Алтернатив	174,498	3.6	0		-24
Миний санал тоологдсон	46,329	1.0	0		Шинэ
Австрийн Коммунист нам нэмэх	36,608	0.8	0		0
Цагаанууд	8,921	0.2	0		Шинэ
Австрийн Чөлөөт жагсаалт	8,692	0.2	0		Шинэ
Ирээдүйн шинэ хөдөлгөөн	2,723	0.1	0		Шинэ
Улс төрд орон гэргүй	658	0.0	0		Шинэ
Социалист зүүний нам	631	0.0	0		0
ЕХ-ноос гарах нам	499	0.0	0		0
Австрийн Христийн нам	424	0.0	0		0
Эрэгтэйчүүдийн нам	220	0.0	0		0
Хүчингүй/хоосон санал	46,805		-	-	
<b>Нийт</b>	<b>4,483,479</b>		<b>100</b>	<b>183</b>	
Бүртгэлтэй сонгогч/ирц	6,400,998		70.0	-	

## Сонгуулийн мэтгэлцээн



Парламентийн сонгуульд нэр дэвшигчдийн дунд зохион байгуулсан мэтгэлцээнээр намууд иргэдийн шилжин суурьших асуудал, гэмт хэрэг, аюулгүй байдал, татвараас чөлөөлөх, ажлын байр бий болгох, ажилгүйдлыг бууруулах болон тэтгэвэр, өндөр настны халамж гэх сэдвүүдээр мэтгэлцжээ.



**Австрийн Ардын намын дарга Себастиан Курз** (1986.8.27-нд төрсөн 31 настай) нь 2013 оноос 27-н насандаа тус улсын Гадаад харилцааны сайдаар ажилласан нь Европын хамгийн залуу сайдаар нэрлэгдэж байжээ. Энэ оны 5-р сард тэрээр Австрийн Ардын намын даргаар томилогдсон. Түүний удирдсан нам 2017 онд Хууль тогтоох байгууллагын сонгуулиар түүний нам Үндэсний зөвлөлд ихэнх суудлыг авсанаар ирэх жилүүдэд Австри Улсын Засгийн газрыг тэргүүлэхээр болж байна.